

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСГИЙН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2015.12.31

Ховд

Д/д	Төсвийн шууд захирагчийн гэрээнд тухайн нэгж хариуцахаар тусгагдсан арга хэмжээ (гарц буюу ажил, үйлчилгээ)	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-ийн хүрэх түвшин	Хэрэгжилт	Үнэлгээ (хувиар)
1	2	3	4	5
НЭГ. БАЙГУУЛЛАГА (НЭГЖ)-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ				
<p>1.0. “ХШҮ-ний тасгийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх замаар аймгийн Засаг даргын бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ» ” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:</p>				
1	1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт тооцох, үр дүн, мэдээ тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний дагуу бүрэн биелж, графикт хугацаандаа хэрэгжсэнээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан байна. (Хагас бүтэн жилээр)	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймаг, орон нутгийн хэмжээнд 5 бодлого, 12 зорилтын хүрээний 94 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн ажлын төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2015 онд 17 сумын төсвийн 85 байгууллага, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 34 байгууллагад хэрэгжүүлж буй Засгийн газрын	90

			<p>үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн явцтай танилцан заавар зөвлөгөө, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Хөтөлбөрийн 2015 оны жилийн эцсийн биелэлтийг 2016 оны 2 дугаар сарын 01-ны дотор хугацаанд гаргаж, www.unelgee.gov.mn сайтад оруулж, баталгаажуулахаар ажиллаж байна.</p> <p>Гарсан үр нөлөө: Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагт хэрэгжүүлэх 94 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлсноор аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.</p>	
2	1.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, мэдээ тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. (Жилийн эцсээр)	<p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловруулан хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Хүн амьдрах таатай орчинтой, үйлдвэрлэл, бизнест ээлтэй, ногоон хөгжлийн загвар аймаг” болох эрхэм зорилгыг тодорхойлж 5 бүлэг, 16 дэд бүлэг, 454 заалттай төлөвлөгөө гаргаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд “Төрийн үйлчилгээг шуурхай болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлэн үр дүнтэй, амжилттай ажиллаж байна.</p>	100

			<p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын дундаж хувь өмнөх оны мөн үеийнхээс 21.3 хувиар өсч, 2014 оны жилийн эцсийн байдлаар 58.9 хувьтай, “хангалттай сайн” хэрэгжсэн гэсэн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.</p> <p>Энэ нь тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлтийг хөтөлбөрийн зорилтын хүрээнд орон нутгийн нөөц бололцоог дайчлан оновчтой зохион байгуулалтыг хийж ажилласны үр дүн юм.</p> <p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2014 оны жилийн жилийн эцсийн биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хөтөлбөрийн биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	
3	1.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, хуралдааны тэмдэглэлийн биелэлт тооцох, тайлагнах	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, хуралдаан тэмдэглэлийг орон нутгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох сум, байгууллагуудад хүргүүлж, хагас бүтэн жилээр биелэлт тооцон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнасан байна. (Хагас бүтэн жилээр)	<p>2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 21, Тэргүүлэгчдийн 88 тогтоолыг хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, давхардсан тоогоор 306 хувь олшруулж хэлтэс, тасаг, сум, байгууллагуудад хүргүүллээ.</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 108 тогтоол шийдвэрийн 181 заалтын биелэлт жилийн эцсийн байдлаар 83.0 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ.</p> <p>Тогтоол шийдвэрийн биелэлтийг 2015 оны жилийн байдлаар тооцож, ИТХ-ын ажлын албанд албан тоотоор хүргүүллээ.</p>	100
4	1.4. Ерөнхийлөгчийн зарлиг,	Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн	Тайлант онд Засгийн газрын 37 тогтоол, 16	100

	Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт тооцох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах	газрын тогтоол шийдвэрийг орон нутгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох сум, байгууллагуудад хүргүүлж, хагас бүтэн жилээр биелэлт тооцон, үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнах. (Хагас бүтэн жилээр)	хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж 2-ыг хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулж, хэлтэс, тасаг, сум, байгууллагуудад давхардсан тоогоор 405 хувь олшруулан хүргэж, сурталчилан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллалаа. 2015 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 161 тогтоол шийдвэрийн 242 заалтын биелэлт 91.7 хувьтай хэрэгжсэнийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, www.unelgee.gov.mn сайтад хугацаанд нь шивж баталгаажуулав.	
5	1.5. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, баг, төрийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	Төлөвлөгөөний дагуу сум, байгууллагуудад хийгдсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой, тухайн сум байгууллагын цаашдын хөгжилд тодорхой ахиц дэвшил гаргах үндэслэл болох түвшинд хийгдсэн байна. Байгууллага, сум, багийн ажил Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогыг бүрэн хэрэгжүүлж, хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн байна. (хагас, бүтэн жилээр)	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний албан байгууллагуудын 2014 оны жилийн эцсийн ажил дүгнэсэн ажлын хэсгийн өгсөн зөвлөмж, дүгнэлтийн мөрөөр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний алба, Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, Үйлдвэр хөдөө аж ахуйн газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцон, арга зүйн зөвлөгөө өгөв. Мөн аймгийн Засаг даргын 2015 оны А/569 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 17 сумын 85 төсвийн байгууллага, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 34 байгууллагын үйл ажиллагаанд 26 үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.	90

6	1.6. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ- үнэлгээний тайланг боловсруулж, Монгол улсын Засгийн газарт хүргүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийснээр аймаг, сум, байгууллагуудын ажил сайжирах, үр дүнг үнэн зөв мэдээлэх. (Дараа оны 4 дүгээр сарын 1-ний дотор)	Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2014 оны тайланг Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ийн дагуу боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэв.	100
7	1.7. Шадар сайд болон яамдын сайд нартай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнах	Сайдуудтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт хангагдаж, ЗГХЭГ-т хүргэгдсэн байна. (Хагас бүтэн жилээр)	Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2014 оны тайлангийн хамт үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, 2015 оны үнэлгээг 2016 оны 4 дүгээр сарын 01-ны дотор гаргаж, хүргүүлэхээр ажиллаж байна.	70
8	1.8. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнах	Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний боловсруулалт, хэрэгжилтэнд тодорхой үр дүн гарсан байна. (Хагас, бүтэн жилээр)	Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчийн 2014 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд 92 хувьтай “А” үнэлгээ өгсөн дүгнэлтэнд “Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд аймгийн гол зорилтууд амжилттай хэрэгжиж байна” гэсэн үнэлгээ өгсөн байна. Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн ба Төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний үнэлгээний дундаж 89.9 буюу “Сайн” үнэлгээ авсаныг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2014 оны тайлангийн хамт 2015 оны 3 дугаар сард Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100

9	<p>1.9. Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргаас эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын даргатай байгуулсан Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний боловсруулалт, биелэлтэнд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх</p>	<p>Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний боловсруулалт, хэрэгжилтэд тодорхой үр дүн гарсан байна. (Хагас, бүтэн жилээр)</p>	<p>Аймгийн Засаг дарга эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллагын төсвийн шууд захирагч нартай Төсвийн тухай Монгол улсын хуулийн 40 дүгээр зүйлийн 40,1, 40,2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу аймгийн хэмжээнд нийт арга хэмжээ 1058, тусгай захиалгат арга хэмжээ 218, манлайллын зорилт 203, нийт 1479 хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Аймгийн Засаг даргаас байгууллагуудын төсвийн шууд захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцож үзэхэд нийт арга хэмжээний биелэлт дунджаар 27.7 хувь, тусгай арга хэмжээний биелэлт 36.13 хувь, манлайллын зорилт 27.86 хувьтай аймгийн хэмжээнд дундажаар 91.42 хувийн биелэлттэй 4.58 оноотой, “А” үнэлгээтэй биелсэн нь өмнөх оны үнэлгээнээс 0.3 хувиар ахисан байна. Гэрээний дүнг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2014 оны тайлангийн хамт 2015 оны 3 дугаар сард Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	100
10	<p>1.10. Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний боловсруулалт, биелэлтэнд</p>	<p>Төсвийн шууд захирагч, аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний боловсруулалт, хэрэгжилтэнд тодорхой үр дүн гарсан байна (Улирлаар)</p>	<p>Аймгийн Засаг дарга 17 сумын Засаг дарга нартай Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.3 заалтуудыг үндэслэн “Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд”, “Засгийн газрын</p>	100

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх		<p>зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд”, “Аймгийн Засаг даргаас нэмэлтээр үүрэг болгож буй арга хэмжээнүүд” гэсэн 3 хавсралт 111 заалт бүхий “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулан ажилласан байна. Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласны дүнд аймгийн дундаж үзүүлэлт 86,39 хувьтай, 4.31 оноотой “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Аймгийн Засаг даргын өмнө хүлээсэн үүргээ сумдын Засаг дарга нар “сайн” биелүүлсэн байна.</p> <p>Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай 2014 онд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлт өмнөх 2013 оны гэрээний биелэлттэй харьцуулахад 1.97 хувиар буурсан байна. Энэ нь 2014 онд улс, орон нутгийн эдийн засаг хүндэрч орон нутагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ёстой байсан зарим ажил, үйлчилгээ тасарсантай холбоотой байна.</p> <p>Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2014 оны тайлангийн хамт үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	
11	1.11.Ерөнхий сайдаар батлуулсан аймгийн Засаг даргын мөрдөж ажиллах зарчмын биелэлт, үр дүнд	Батламжийн заалтууд бүрэн хэрэгжсэн байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан байна. (Хагас бүтэн жилээр)	Ерөнхий сайдаар батлуулсан аймгийн Засаг даргын мөрдөж ажиллах зарчмын гэрээний биелэлтийг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу тооцож, хяналт-шинжилгээ,	100

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүнг Засгийн газарт хүргүүлэх		үнэлгээ хийсэн дүнг тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.	
12	1.12. Аймгийн Засаг даргаар батлуулсан сумдын Засаг дарга нарын мөрдөж ажиллах зарчмын биелэлт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Гэрээний заалтууд бүрэн хэрэгжсэн байна. (Бүтэн жилээр)	Аймгийн Засаг даргаар батлуулсан сумдын Засаг дарга нарын мөрдөж ажиллах зарчмын гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлэв.	90
13	1.13 Төсвийн мөнгөөр хийгдсэн зарим ажил үйлчилгээнд иргэдийн оролцоотой мониторинг хийх	Хяналт үнэлгээний ил тод байдал хангагдсан байна.	Тасарсан	0
14	1.14 УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтэнд ХШҮ хийх, тайлагнах	УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл бүрэн биелж, графикт хугацаандаа хэрэгжсэн байна. (Дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор)	Холбогдох хэлтэс, албан байгууллагууд яамдад хүргүүлсэн.	100
15	1.15 Төрийн байгууллагуудын ил тод байдлын үнэлгээний тайланд ХШҮ хийх	Хуулиар хориглогдоогүй бүх үйл ажиллагаа иргэдэд ил тод нээлттэй болсон байна (Улирлаар)	Сум, байгууллагын ажлын ил тод байдлын үнэлгээг хийхдээ “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль ба Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хавсралтад зааснаар 4 бүлэг 34 шалгуур үзүүлэлтийн дагуу 100 хүртэл оноогоор үнэлэхэд 5 сум хангалттай сайн, 9 сум хангалттай, 3 сум сайжруулах шаардлагатай үнэлгээ авч сумдын ерөнхий дундаж 87.6 хувьтай “Сайн” үнэлгээтэй, Засаг даргын дэргэдэх агентлагуудаас 8 байгууллага хангалттай сайн, 17 байгууллага хангалттай, 6	90

			<p>байгууллага сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээ авч байгууллагын дундаж 80.6 хувь буюу 4.2 оноогоор “ Сайн” үнэлгээ авсан байна.</p> <p>Хяналт, үнэлгээний дүнгээс үзэхэд сумдын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдал өмнөх оныхоос илүү сайжирч, сумдын Засаг даргын Тамгын газар ба төсөвт байгууллага, дээд шатны байгууллага хоорондын ажил уялдаатай, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож, төлөвлөж ажилладаг болсон байна.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулахад олон нийтийг оролцуулдаг, зээлийн эргэн төлөлт хэвийн, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг бодлогоор дэмждэг, залуу малчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, малжуулах талаар ихээхэн анхааран ажиллаж байна.</p> <p>Засаг даргын дэргэдэх агентлагуудын хувьд харилцан адилгүй боловч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээлэл бэлтгэн, шинэчлэх, хэрэглэгчдийн сэтгэгдэл үлдээх боломжтой байх, веб сайтад хандсан үйлчлүүлэгчдийн тоог харагдахуйц байх талаар нийтлэг анхаарч ажиллах хэрэгтэй байна.</p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангах ажилд Хөдөлмөрийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн</p>	
--	--	--	---	--

			хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба сайн ажилласан байна.	
16	1.16 Аймгийн хэмжээний хэрэглэгчийн үнэлгээний дүнг авч нэгтгэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах	Төрийн үйл ажиллагааг иргэдээр үнэлүүлснээр төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ сайжирч, сайн засаглал бий болно (Жилийн эцэст)	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 60 дугаар зүйлд заасаны дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/595 дугаар захирамжаар “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг батлууллаа. Журмын дагуу төрийн бус байгууллагуудын дунд сонгон шалгаруулалт зарлаж, сонгон шалгаруулалтад “Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн”, “Усалгаат газар тариалан эрхлэгчдийн холбоо”, “Ховд Бат-Итгэл” төрийн бус байгууллагууд оролцов. Аймгийн ЗДТГ-аас тавьсан шаардлага, болзолыг хангасан “Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” төрийн бус байгууллага шалгарч аймгийн Засаг даргын Тамгын газартай 4 сая төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан, “Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжид өгсөн 2014 оны хэрэглэгчийн үнэлгээ”-г гүйцэтгэж, үнэлгээний тайланг гаргасан. Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжид өгсөн хэрэглэгчийн үнэлгээний дүн өмнөх оноос 6.53 хувиар өссөн дүнтэй гарлаа. Хэрэглэгчийн үнэлгээний тайланд тусгагдсан санал, дүгнэлтийн мөрөөр үнэлгээнд хамрагдсан Жаргалант сумын ЗДТГ, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, ГХБХБГ, БОЭТ-	100

			ийн удирдлагууд болон холбогдох албан тушаалтан, ТББ-ын төлөөллийг оролцуулан 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Хяналт шинжилгээ, үнэлгээний тасгаас хэлэлцүүлэг зохион байгуулсан нь үр өгөөжөө өгсөн томоохон ажил боллоо. Хэлэлцүүлгийн дүнд үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын ажил, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын албан даалгавар, зөвлөмж гарган сум, байгууллагуудад хүргүүлээд байна.	
17	1.17. Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд ХШҮ хийх, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газруудын ажлын үр дүн сайжирна.	Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2015 оны 05 дугаар хуралдаанаар “Шим ус”, “Ховд-Эрч хүч”, “Ховд Суврага” ОНӨААТҮГ-уудын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд өргөн барьж шийдвэрлүүлэв. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Шим ус”, “Ховд-Эрч хүч”, “Ховд Суврага”, “Мянган Угалзат” ОНӨҮГ-уудын 2015 оны үйл ажиллагаанд ХШҮ хийж, зөвлөмж хүргүүлэв.	70
18	1.18 Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод үйл ажиллагаанд мониторинг хийх	Засаг даргын Тамгын газрын ажил, үйлчилгээний чанар сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аппараттын хуралд танилцуулж, хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэв.	100

19	1.19 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээний чанарт мониторинг хийх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй боловсролын талаарх төрийн бодлогын хэрэгжилтэд бодит байдлыг тогтооно.	Тасарсан	0
ХОЁР Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилд өмнөө тавьсан зорилтыг бүрэн хэрэгжүүлэх, төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод хүргэх албан хаагч нарын нэр хүнд, манлайлалыг хангах” “ гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:				
20	2.1. Хувийн ашиг сонирхлын тухай болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргах, цагийн менежментийг ажилдаа нэвтрүүлэх	Хувийн ашиг сонирхлын тухай болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлнэ. (Жилийн эцэст)	Тасгийн дарга Ц.Оюунцэцэг, ахлах мэргэжилтэн Х.Дарьгерхан, мэргэжилтэн Б.Бурмаа нар хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэв.	100
21	2.2. Архив албан хэргийг стандартын дагуу хөтлөх	Архивыг хуулийн хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна. (Жилийн эцэст)	2014 оны материалуудыг архивлаж, 43 баримт бүрдүүлэн хуулийн хугацаанд бичиг хэрэгт хүлээлгэн өгөв.	100
22	2.3. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчын ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчын эрхэмлэх 9 зүйлийг өдөр тутам мөрдөх	Ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан байна. (Жилийн эцэст)	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн хамт олон тайлант онд ёс зүйн ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажилласан байна.	100
23	2.4.Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод хүргэх, албан хаагч нарын нэр хүнд, манлайлалыг хангаж ажиллах	Хүнд суртал, авлига, хээл хахуулаас урьдчилан сэргийлж, төрийн албаны нэр хүнд сайжирч, иргэд төрд итгэх итгэл үнэмшил бий болно. (Байнга)	Тус тасгийнхан иргэдэд төрийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэж, албан хаагчдын нэр хүнд, манлайлалыг ханган ажиллалаа.	100
	2.5 Аймгийн вэб сайт болон мэдээллийн самбарт ХШҮ-	Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан үйл	www.khovd.gov.mn сайтад тасгийн жилийн ажлын төлөвлөгөө болон бусад холбогдох	100

24	ний тасгаас зохион байгуулсан ажлын мэдээллүүдийг байнга тавьж байх	ажиллагааны ил тод байдал хангагдана, иргэд ХШҮ-ний талаар тодорхой мэдээлэлтэй болно.	мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулсан болно.	
25	2.6 Хугацаатай бичгийг хяналтандаа авч хугацаанд нь хариу өгч байх, мэдээ, тайланг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан хугацаанд холбогдох газарт явуулж байх	Мэдээ, мэдээлэл хугацаа алдахгүй тухайн байгууллагад хүрсэн байна.	Хугацаатай бичгийг хяналтандаа авч хугацаанд нь шийдвэрлэж, Монгол Улсын Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2015 оны жилийн биелэлтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт ЗГХЭГ-т хүргүүлж, www.unelgee.gov.mn сайтад хугацаанд нь шивж баталгаажууллаа.	100
3. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ				
26	3.1 Сум, байгууллагаас ирүүлж байгаа тайлан мэдээний тэмдэглэл хөтлөх, үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх		Сум, байгууллагуудаас ирүүлсэн хөтөлбөр, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцтай танилцаж, заавар зөвлөгөө өгч ажиллав. Мөн тайлан, мэдээг хугацаа хоцруулж ирүүлсэн сум, байгууллагуудын судалгааг гаргаж байна.	70
27	3.2 Тасгаас гаргаж буй мэдээ тайлан, зөвлөмж бичиг баримтын боловсруулалт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Тасгаас гаргаж буй мэдээ тайлан, зөвлөмж бичиг баримтын боловсруулалт, хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллаж байна.	100
28	3.3 Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргаас өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэх		Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргаас өгсөн чиг үүргийг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллассан.	70
29	3.3 ХШҮ-ний цахим мэдээллийн сангийн программыг нэвтрүүлэх		Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2015 оны эхний хагас жилийн биелэлтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн, хурлын	70

		тэмдэглэлийн хамт ЗГХЭГ-т хүргүүлж, www.unelgee.gov.mn хугацаанд нь шивж баталгаажуулав.	
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ			

Тайлбар: Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 29 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 18, 90 хувийн хэрэгжилттэй 4, 70 хувийн хэрэгжилттэй 5, тасарсан 2 арга хэмжээ 86.6 хувийн биелэлттэй байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ